

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2023.12.25

Улаанбаатар хот

Улсын бүртгэлийн ерөнхий газрын “Ёс зүйн зөвлөл”-ийг 7 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2020 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн А/1365 дугаар тушаалаар байгуулж, 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/1510 дугаар тушаалаар “Улсын бүртгэлийн ерөнхий газрын Ёс зүйн зөвлөлийн ажиллах журам”-ыг баталсан.

“Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль” 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрөөс хүчин төгөлдөр болсноор Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн А/1713 дугаар тушаалаар “Ёс зүйн зөвлөл”-ийг “Ёс зүйн дэд хороо” болгон өөрчилсөн.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын албан хаагчид төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний хэрэгжилтийг хангаж, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”, “Улсын бүртгэлийн ерөнхий газрын Ёс зүйн зөвлөлийн ажиллах журам”-ыг тус тус мөрдөн ажиллаа. Ёс зүйн дэд хороо 2023 онд ёс зүйн зөрчилтэй холбоотой 10 өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авч, шийдвэрлэж, 11 удаа хуралдсан байна.

Зөвлөлийн тогтоол шийдвэрийг өргөдөл гомдол гаргагч болон албан хаагчдад тухай бүр хугацаанд нь танилцуулж холбогдох арга хэмжээг авч, албажуулсан. “Сануулах” хариуцлагыг 3 албан хаагчид, “Уучлал гуйхыг үүрэг болгох” хариуцлагыг 4 албан хаагчид хүлээлгэсэн болно. Улсын бүртгэлийн байгууллагын Хүний нөөц, сургалтын цахим системд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай видео хичээл байршуулсан бөгөөд хичээлийг 72 албан хаагч үзэж судалсан байна. Мөн аймаг, нийслэлийн Улсын бүртгэлийн газар, хэлтэст шинээр томилогдсон 107 албан хаагчдад “Ёс зүйн хэм хэмжээ” сэдвээр 3 удаагийн сургалтыг зохион байгуулсан. Мөн Төрийн албаны зөвлөлөөс 7 хоног бүрийн Пүрэв гарагийн 10:00 цагаас төрийн албан хаагчдыг чадавхжуулах “7:4:10” вебинар сургалтад 12 удаа давхардсан тоогоор 561 албан хаагч хамрагдсан.

Нийслэлийн Улсын бүртгэлийн газраас шинээр томилогдсон албан хаагчдад зориулан улсын бүртгэлийн хууль тогтоомж, дотоод журам, авлигаас урьдчилан сэргийлэх, Авлигын эсрэг хуулийн хэрэгжилтийг хангах, төрийн албаны болон улсын бүртгэлийн байгууллагын албан хаагчийн ёс зүй, байгууллагын үйлчилгээний стандарт, тус газрын бүтэц, чиг үүргийн тухай мэдлэг, мэдээлэл олгох байгууллагын соёлыг танилцуулах сургалтыг 2023 оны 02 дугаар сарын 7,8-ны өдрүүдэд зохион байгуулж, нийт 35 албан хаагч хамрагдсан.

Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын даргын баталсан “Ёс зүйн зөрчилгүй хамт олон” аяны хүрээнд 2023 оны 11 дүгээр сарын 2, 3-ний өдрүүдэд Монгол Улсын Төрийн албаны тухай хууль, шинээр батлагдсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль”-ийн танилцуулга, албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг мөрдүүлэх сурталчлан таниулах, зөв харилцаа хандлагыг төлөвшүүлэх, хууль, эрх зүйн мэдлэг олгох зэрэг сэдвээр 4 удаагийн цахим сургалт зохион байгууллаа. Сургалтыг “Эрдэм” сургалт, судалгааны хүрээлэнгийн захирал, доктор, профессор Б. Өлзийсайхан “Төрийн албан

хаагчийн ёс зүйн тухай хуулийн үзэл баримтлал” сэдвээр хичээл зааж, сургалтад Нийслэлийн Улсын бүртгэлийн газар, хэлтсийн нийт 265 албан хаагчид хамрагдав. Мөн аяны хүрээнд 360 албан хаагчтай “Ёс зүйн гэрээ” байгуулсан. Төрийн албаны зөвлөлөөс явуулсан “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдвээр 15 удаагийн сургалтад 247 албан хаагч хамрагдав. 2023 оны 11 дүгээр сарын 10-ний өдөр АНУ-ын Калифорни мужийн их сургуулийн магистр багш Б.Баярмаа “Стресс менежмент” сэдвээр сургалт хийж, сургалтад 24 албан хаагч хамрагдсан байна.

Ёс зүйн дэд хороонд 2023 онд ирүүлсэн зөрчлүүдийн шинжлэн нэгтгэн дүгнэвэл хүнд суртал, харилцааны доголдол, мэдлэг, ур чадварын дутмаг байдал зэрэг илэрч байна. Алба хаагчдыг чадавхжуулах, ёс зүйн хэм хэмжээний талаар сургалтыг давтамжтай зохион байгуулах, мэргэжлийн түвшинд чадавхижуулах сургалтыг оруулах саналыг Тамгын газрын Хамтын ажиллагаа сургалтын хэлтэст хүргүүлэн 2024 оны байгууллагын сургалтын төлөвлөгөөнд тусгахаар ажиллаж байна.